



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 38 (419)

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- *Монгол Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай*

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- *2005 онд хувьчлах, өөрчлөн байгуулах хуулийн этгээдийн жагсаалт батлах тухай*
- *Төрийн өмчийн байрны тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2005 он



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ  
Долоо хоног тутмын

Улаанбаатар хот

2005 оны аравдугаар сарын 14

№38 (419)

## Гарчиг

### Нэг. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

948.	Монгол Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай	Дугаар 53	781
949.	Монгол Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай	Дугаар 54	782
950.	Байнгын хорооны гишүүнээр батлах тухай	Дугаар 55	782

### Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

951.	Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай	Дугаар 172	782
952.	2005 онд хувьчлах, өөрчлөн байгуулах хуулийн этгээдийн жагсаалт батлах тухай	Дугаар 176	782
953.	Зардлын дундаж норматив батлах тухай	Дугаар 177	786
954.	Төрийн өмчийн байрны тухай	Дугаар 181	787
955.	Хөрөнгө гаргах тухай	Дугаар 182	787
956.	Комиссын бүрэлдэхүүн, журам батлах тухай	Дугаар 183	788
957.	Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай	Дугаар 184	790
958.	Техникийн төвийг татан буулгах тухай	Дугаар 185	791
959.	Ажилд томилох тухай	Дугаар 187	791
960.	Нэрэмжит болгох тухай	Дугаар 188	791
961.	Үндэсний шигшээ баг байгуулах тухай	Дугаар 189	792
962.	Хамгаалалтын бүс тогтоох тухай	Дугаар 191	792
963.	Хэлэлцээр батлах тухай	Дугаар 194	792

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2005 оны 10 дугаар  
сарын 03-ны өдөр

Дугаар 53

Улаанбаатар  
хот

#### Монгол Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 65  
дугаар тойрогт 2005 оны 8 дугаар сарын 28-ны өдөр  
явуулсан нөхөн сонгуулийн дүнг үндэслэн Монгол  
Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:  
Монгол Улсын Их Хурлын гишүүнээр

сонгогдсон Миезгомбын Энхболдын Бүрэн эрхийг  
хүлээн зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Ц.НЯМДОРЖ



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2005 оны 10 дугаар сарын 03-ны өдөр

Дугаар 54

Улаанбаатар хот

### Монгол Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 24 дүгээр тойрогт 2004 оны 6 дугаар сарын 27-ны өдөр явуулсан ээлжит сонгуулийн дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

сонгогдсон Зандаахүүгийн Энхболдын бүрэн эрхийг хүлээн зөвшөөрсүгэй.

Монгол Улсын Их Хурлын гишүүнээр

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Ц.НЯМДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2005 оны 10 дугаар сарын 03-ны өдөр

Дугаар 55

Улаанбаатар хот

### Байнгын хорооны гишүүнээр батлах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, өөрсдийнх нь гаргасан хүсэлтийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Улсын Их Хурлын гишүүн Миезгомбын Энхболдыг Аюулгүй байдал, гадаад бодлогын, Төрийн байгуулалтын болон Төсвийн байнгын хорооны гишүүнээр тус тус баталсугай.

2. Энэ тогтоолыг 2005 оны 10 дугаар сарын 3-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

1. Улсын Их Хурлын гишүүн Зандаахүүгийн Энхболдыг Аюулгүй байдал, гадаад бодлогын, Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн хөгжлийн болон Эдийн засгийн байнгын хорооны гишүүнээр,

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Ц.НЯМДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2005 оны 8 дугаар сарын 24-ний өдөр

Дугаар 172

Улаанбаатар хот

### Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай

Усны тухай хуулийн 8.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

ны өдрийн 51 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

Усны тоо бүртгэл явуулах журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлах болсонтой холбогдуулан "Журам батлах тухай" Засгийн газрын 1996 оны 3 дугаар сарын 6-

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД**

**Ц.ЭЛБЭГДОРЖ**

**БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙД**

**У.БАРСБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2005 оны 8 дугаар сарын 24-ний өдөр

Дугаар 176

Улаанбаатар хот

### 2005 онд хувьчлах, өөрчлөн байгуулах хуулийн этгээдийн жагсаалт батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 4 дэх заалт, 33 дугаар зүйл, Улсын Их Хурлын 2005 оны 48 дугаар тогтоолоор баталсан "Төрийн өмчийг 2005-2008 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл"-ийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

хангуулах хуулийн этгээдийн жагсаалт"-ыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Энэхүү тогтоолыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хэрэгжүүлж үр дүнг Засгийн газарт танилцуулахыг Төрийн өмчийн хороо (З.ЭНХБОЛД)-нд даалгасугай.

1. "2005 онд хувьчлах хуулийн этгээдийн жагсаалт"-ыг 1 дүгээр, "2005 онд өөрчлөн байгуулалт хийх болон хувьчлалын бэлтгэл

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД**

**Ц.ЭЛБЭГДОРЖ**

**САНГИЙН САЙД**

**Н.АЛТАНХУЯГ**



## 2005 ОНД ХУВЬЧЛАХ ХУУЛИЙН ЭГТЭЭДИЙН ЖАГСААЛТ

№	Байгууллагын нэр	Байршил	Төрийн эзэмшлийн хувь, хэмжээ	Хувьчлалыг зарлах хугацаа	Хувьчлах арга, хэлбэр, нөхцөл
1	"Шаргалжууг" рашаан сувилал	Баянхонгор, Баянхонгор сум	100	III улирал	Үйлчилгээний чиглэлийг өөрчлөхгүйгээр нэмэлт хөрөнгө оруулалт хийх нөхцөлтэйгээр уралдаант шалгаруулалтын аргаар гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид хувьчлах
2	"Монгол тэмэний ноос" ТӨҮГ	Улаанбаатар, Хан-Уул	100	III улирал	Дуудлагын худалдаагаар худалдах
3	"Монгол-өрдэнэ" ТӨҮГ	Улаанбаатар	100	III улирал	Дуудлагын худалдаагаар худалдах
4	"Төв Азийн Уран" ХХК	Дорнод, Мардай	21	II хагас жил	Канадын талд санал болгон худалдах, татгалзсан нөхцөлд дуудлагын худалдаагаар хувьчлах
5	"Капитал банк" дахь төрийн эзэмшлийн хувь	Улаанбаатар, Чингэлтэй	8.72	II хагас жил	Компанийн хуулийн дагуу бусад хувьдаа эзэмшигчдэд санал болгох, татгалзсан нөхцөлд нийтийн дуудлагын худалдаагаар худалдах
6	Халгаламжийн банк	Улаанбаатар, Чингэлтэй	100	III улирал	Олон улсын нээлттэй уралдаант шалгаруулалтын аргаар хувьчлах
7	"Хан-Орд" ХК	Улаанбаатар, Сонгинохайрхан	34.67	III улирал	Хөрөнгийн биржээр дамжуулан хувьдааг нь арилжих
8	Улсын шүрк	Улаанбаатар, Сүхбаатар	100	IV улирал	Үйл ажиллагааны чиглэлийг өөрчлөхгүй байх, улсын төсвөөс авах санхүүжилтийг бууруулах нөхцөлтэйгээр уралдаант шалгаруулалтаар сонгогдсон удирдлагын багт менежментийн үр дүнг харгалзан хувьчлах
9	Клиникийн нэгдсэн Ш эмгэлэг	Улаанбаатар, Баянгол	100	III улирал	Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдад нэмэлт хөрөнгө оруулалт хийх нөхцөлтэйгээр, улирдах үйл ажиллагааны үр дүнг харгалзан хувьчлах

**2005 онд ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАЛТ ХИЙХ БОЛОН ХУВЬЧЛАЛЫН  
 БЭЛТГЭЛ ХАНГУУЛАХ ХУУЛИЙН ЭГТЭЭДИЙН ЖАГСААЛТ**

д/д	Байгууллагын нэр	Байршил	Төрийн өмчийн оролцооны хувь	Өөрчлөн байгуулалт хийх, хувьчлалын бэлтгэл хангахад авах арга хэмжээ
1	"Монголын шахилгаан холбоо" ХК	Улаанбаатар, Чингэлтэй	55	1. "Монголын шахилгаан холбоо" ХК-д түрээслэж байгаа төрийн өмчийн хөрөнгөөс монополий шинжтэй суурь болон салбар сүлжээний хэсгийг тусгаарлан зөвхөн сүлжээний үйлчилгээ явуулах бие даасан төрийн өмчийн компанийг шинээр байгуулах 2. Төрийн өмчийн АТС-ууд болон түүнтэй холбоотой зарим хөрөнгөд дахин үнэлгээ хийж "Монголын шахилгаан холбоо" ХК-д шилжүүлэн төрийн өмчийн хувицааг нэмэгдүүлэх талаар Солонгосын талтай тохиролцох 3. Тус компанийн төрийн мэдлийн хувицааг худалдан авахыг БНСУ-ын Корей Телеком компанид гэрээний дагуу санал болгож хариуг албан ёсоор авах 4. Шуудан, шахилгаан холбооны газрын Японы тусламжийн хөрөнгөөр авсан тоног төхөөрөмжийг "Монголын шахилгаан холбоо" ХК түрээсээр ашигладаг асуудлыг шийдвэрлэн тусламжийн орлогыг төвлөрүүлэх арга хэмжээ авах.
2	"Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨҮГ	Дархан-Уул	100	Хувицаат компанийн хэлбэрт шилжүүлэх
3	"Дарханмахэксно" ХК	Дархан-Уул, Дархан	51	Японы Засгийн газрын буцалтгүй тусламжийн хөрөнгийг хэрхэн шийдвэрлэх талаар Японы талтай зөвшилцөж тохиролцоонд хүрэх
4	"Эрдэнэ зам" ХК	Улаанбаатар, Баянзүрх	100	Японы Засгийн газрын буцалтгүй тусламжийн хөрөнгийг хэрхэн шийдвэрлэх талаар Японы талтай зөвшилцөж тохиролцоонд хүрэх

5	Монрошцөгмет нэгдэл	Улаанбаатар, Баянзүрх	51	Үйлдвэрүүдийн техник, тоног тохөөрөмжийг шинэчлэх, удирдлагын нүүсэр бүтцийг оновчтой болгох, үр ашгийг дээшлүүлэх, тэлгээрийг түшиглэсэн хот, төстодмы соёл, боловсрол, үйлчилгээний зориулалттай нэгжүүдийн хэвийн үйл ажиллагааг асдагдуулахгүй байх ноёдөөлөөр хувьчлах, өөрчлөн байгуулах боломжийг хоёр улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хүрээнд Оросын талтай зөвшилцөх
6	Хөтөлвийн "Цемент-шокой" ТӨХК	Сэлэнгэ, Сайтхан	100	Хуримтлагдсан өр, төлбөрийн асуудлыг шийдвэрлэх
7	Иргэний нисэхийн ерөнхий газар	Улаанбаатар, Хан-Уул	100	1. Иргэний нисэхийн ерөнхий газрыг нислэгийн хөдөлгөөний үйлчилгээг нэгдсэн удирдлагаар ханган, нэгтгэн зохион байгуулах, иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, салбарын эдийн засгийн зохицуулалтыг харуушиг хэрэгжүүлэх Үүрэг бүхий хэрэгжүүлэгч агентлагийн статустайгаар хэвээр үлэх. 2. Шатахууны хангалтын болон газрын үйлчилгээний нэгж, нисэх буудлуудыг бие даасан төрийн өмчит үйлдвэрийн газрын хэлбэрээр зохион байгуулах, шашинд иргэний нисэхийн салбарын эрх зүйн болон эдийн засгийн зохицуулалтын орчныг бүрдүүлсний үйлсэн дээр нисэхийн ийгдлэг үйлчилгээг гэрээт үйлчилгээ, хувийн хэвшилд шилжүүлэх.
8	"МИАТ" ХК	Улаанбаатар, Хан-Уул	100	Газрын үйлчилгээний албадыг "МИАТ" ХК-ийн бүрэлдэхүүнээс гаргах
9	"Рашаан сувиллын үндэсний төв"	Улаанбаатар, Хан-Уул	100	Уламжлалт анагаахын шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэлийн нэгдлийн клиник эмчилгээний 2 удааар салбар буюу хуучин нэрээр Эрчим сувиллын барилга, үндсэн хөрөнгийг эмчилгээний зориулалтыг нь өөрчлөхгүйгээр ЭМЯ-ны харьяа рашаан сувиллын үндэсний төвд /хуучин нэрээр Оргил рашаан сувилал/ балансаас балансад шилжүүлсний дараа төрийн өмчит хувьцаат компанийн хэлбэрт шилжүүлэх.
10	"Авто импекс" ХК	Улаанбаатар, Сонгинохайрхан	51	Төсөвт төлөх гадаад болон дотоод зээлийн өрийн асуудлыг шийдвэрлэх
11	"Монгол кино нэгтгэл" ТӨҮГ	Улаанбаатар, Баянзүрх	100	Баримтат кино студийг тусад нь бие даалган зохион байгуулж, Монгол кино нэгтгэлийг хувираат компанийн хэлбэрт шилжүүлэх



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2005 оны 8 дугаар сарын 24-ний өдөр

Дугаар 177

Улаанбаатар хот

### Зардлын дундаж норматив батлах тухай

Боловсролын тухай хуулийн 40.2, 40.3 болон Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 25.1-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Аймаг, нийслэл дэх хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн анхан шатны ангийн нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын дундаж нормативыг хавсралт ёсоор баталсугай.

2. Ерөнхий боловсролын сургуулийн болон мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн дотуур байранд амьдрах анхан шатны ангийн нэг хүүхдэд ногдох хоолны зардлын хэмжээг жилд 130.0 (нэг зуун гучин) мянган төгрөгөөр тогтоож улсын төсвөөс санхүүжүүлсүгэй.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Зардлын дундаж норматив, жишиг батлах тухай" Засгийн газрын 2004 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн 187 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн "Аймаг, нийслэлийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн анхан шатны ангийн нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын дундаж нормативыг 1 дүгээр хавсралт" гэснийг болон мөн тогтоолын 3 дугаар зүйл, 1 дүгээр хавсралтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**
**Ц.ЭЛБЭГДОРЖ**
**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ  
УХААНЫ САЙД**
**П.ЦАГААН**

Засгийн газрын 2005 оны 177 дугаар тогтоолын хавсралт

### АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГ, ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ, МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ-ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВИЙН АНХАН ШАТНЫ АНГИЙН НЭГ ХҮҮХДЭД НОГДОХ ХУВЬСАХ ЗАРДЛЫН ДУНДАЖ НОРМАТИВ

(мянган төгрөг)

№	Бүс нутаг	Аймаг, хот	Цэцэрлэгийн нэг хүүхдэд ногдох хувьсах зардал	Ерөнхий боловсролын сургуулийн нэг сурагчид ногдох хувьсах зардал			Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн анхан шатны ангийн нэг сурагчид ногдох хувьсах зардал
				Бага анги	Дунд анги	Ахлах анги	
1	Баруун бүс	1.Баян-Өлгий	130.3	81.8	101.8	109.3	188.1
2	Баруун бүс	1.Говь-Алтай 2.Завхан 3.Увс 4.Хөвд		79.3	98.5	105.6	
3	Хангайн бүс	1.Архангай 2.Баянхонгор 3.Булган 4.Өвөрхангай 5.Хөвсгөл 6.Орхон	123.3	77.0	93.8	103.9	180.5
4	Төвийн бүсийн говийн аймгууд	1.Говь-сүмбэр 2.Дорноговь 3.Дундговь 4.Өмнөговь	123.3	77.0	93.8	103.9	180.5
5	Төвийн бүс	1.Сэлэнгэ 2.Төв 3.Дархан-Уул 4.Улганбаатар	122.6	76.5	94.8	103.3	179.3
6	Зүүн бүс	1.Дорнод 2.Сүхбаатар 3.Хэнтий	124.3	77.3	95.7	104.2	184.1

Тайлбар: 1. Дээрх хувьсах зардлын хэмжээнд цалингийн сангийн зэлэх хувь цэцэрлэгт 72.0, ерөнхий боловсролын сургуульд 70.6, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвд 55.0 хувь байна.

2. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын дүнд хоолны зардал ороогүй болно.

## — МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ —

2005 оны 9 дүгээр сарын 2-ны өдөр

Дугаар 181

Улаанбаатар хот

### Төрийн өмчийн байрны тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

хуралдаанд танилцуулахыг Сангийн сайд Н.Алтанхуяг, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Баярцогт, Төрийн өмчийн хороо (З.ЭНХБОЛД)-нд даалгасугай.

1. Төрийн өмчийн Ү байрыг Барилга, хот байгуулалтын яам, Улсын мэргэжлийн хяналтын газар, Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар, Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газрын конторын зориулалтаар Төр, засгийн Үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газрын балансад шилжүүлэхийг Төрийн өмчийн хороо (З.ЭНХБОЛД)-нд зөвшөөрсүгэй.

5. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Төрийн өмчийн зарим байрны тухай" Засгийн газрын 2003 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн 11 дүгээр тогтоолын 1 дүгээр зүйлд "Төрийн өмчийн Ү байрыг Улсын мэргэжлийн хяналтын газар, Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар, Ашигт малтмалын хэрэг эрхлэх газрын конторын зориулалтаар Улсын мэргэжлийн хяналтын газрын балансад" гэснийг хүчингүй болсонд тооцсугай.

2. Барилгыг зохих журмаар хүлээн авч байрны захиргаа байгуулан ашиглалт, үйлчилгээг хариуцан зохион байгуулж ажиллахыг Төр, засгийн Үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газар (Ж.БАДРАА)-т даалгасугай.

3. Төрийн өмчийн байрны захиргаа байгуулан ажиллуулахтай холбогдуулан тус байрны захиргааны орон тоо, төсвийг хянаж, зардлыг нь төсөвт тусган санхүүжүүлэхийг Сангийн сайд Н.Алтанхуягт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН  
ШАДАР САЙД

Ч.УЛААН

4. Засгийн газрын болон Төрийн өмчийн байрны захиргааг аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын зохион байгуулалтад шилжүүлэх асуудлыг судлан, санал боловсруулж Засгийн газрын

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

С.БАЯРЦОГТ

## — МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ —

2005 оны 9 дүгээр сарын 7-ны өдөр

Дугаар 182

Улаанбаатар хот

### Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. АНУ-д байгалийн гамшиг тохиолдсонтой холбогдуулан Засгийн газрын нөөц хөрөнгөөс 50000 (тавин мянган) ам.доллартай тэнцэх хэмжээний хөрөнгийг тус улсад хүмүүнлэгийн тусламжид зориулан гаргахыг Сангийн сайд Н.Алтанхуягт зөвшөөрсүгэй.

2. Хүмүүнлэгийн тусламжийг АНУ-ын талд зохих шугамаар хүлээлгэн өгөхийг Гадаад хэргийн сайд Ц.Мөнх-Оргилд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

Ц.ЭЛБЭГДОРЖ

ГАДААД ХЭРГИЙН САЙД  
САНГИЙН САЙД

Ц.МӨНХ-ОРГИЛ  
Н.АЛТАНХУЯГ





## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2005 оны 9 дүгээр сарын 7-ны өдөр

Дугаар 183

Улаанбаатар хот

### Комиссын бүрэлдэхүүн, журам батлах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 23.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Засгийн газрын комисс, хороо, үндэсний зөвлөл, ажлын хэсгийн тухай" Засгийн газрын 2005

оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн 66 дугаар тогтоолын 7 дугаар хавсралтаар баталсан "Гамшигтай тэмцэх комисс"-ыг "Улсын онцгой комисс" болгон өөрчилж бүрэлдэхүүнийг дор дурдсанаар шинэчлэн баталсугай:

### УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

**Дарга**-Онцгой байдлын асуудал эрхэлсэн Монгол Улсын сайд

**Орлогч дарга:** -Эрхлэх ажлын хүрээнд нь онцгой байдал үүссэн салбарын сайд;

-Онцгой байдлын ерөнхий газрын дарга.

#### Гишүүд:

-Хүнс, хөдөө аж ахуйн сайд;

-Эрүүл мэндийн сайд;

-Байгаль орчны сайд;

-Түлш, эрчим хүчний сайд;

-Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд;

-Зам, тээвэр, аялал жуулчлалын сайд;

-Барилга, хот байгуулалтын сайд;

-Мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн

Монгол Улсын сайд;

-Үйлдвэр худалдааны дэд сайд;

-Нийслэлийн Засаг дарга бөгөөд

Улаанбаатар хотын захирагч;

-Нутаг дэвсгэр дээр нь онцгой байдал үүссэн аймгийн Засаг дарга;

-Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;

-Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;

-Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга;

-Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга;

-Тагнуулын ерөнхий газрын дарга;  
-Цагдаагийн ерөнхий газрын дарга;  
-Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга;  
-Хил хамгаалах ерөнхий газрын дарга;  
-Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газрын дарга;

-Улсын гаалийн ерөнхий газрын дарга;  
-Монголын улаан загалмай нийгэмлэгийн ерөнхий нарийн бичгийн дарга /тохиролцсоноор/.

#### Нарийн бичгийн дарга:

-Онцгой байдлын ерөнхий газрын газар /хэлтэс/-ын дарга.

2. "Улсын онцгой комиссын ажиллах журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Журам батлах тухай" Засгийн газрын 2005 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн 159 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Ц.ЭЛБЭГДОРЖ**

**МОНГОЛ УЛСЫН  
САЙД**

**У.ХҮРЭЛСҮХ**

*Засгийн газрын 2005 оны 183 дугаар тогтоолын хавсралт*

### УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН АЖИЛЛАХ ЖУРАМ

#### Нэг, Нийтлэг үндэслэл

1. Улсын онцгой комисс /цаашид "комисс" гэх/-оос холбогдох төрийн захиргааны байгууллага, тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагаас Гамшгаас хамгаалах тухай хуулинд заасан асуулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, алан хядах ажиллагаа, дэлбэрэлтийн аюулаас хүн ам, мал, амьтан, хүрээлэн байгаа орчныг аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй

сэргээн босгох арга хэмжээ авах, түүнийг хэрэгжүүлэхэд төрийн захиргааны төв болон бусад байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтны үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, шуурхай зохион байгуулах, хяналт тавихад энэхүү журмыг дагаж мөрдөнө.

2. Комисс нь Гамшгаас хамгаалах тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, энэ журмыг удирдлага болгон үйл ажиллагаагаа явуулна.

3. Улсын онцгой комиссын бүрэлдэхүүнийг Засгийн газар, аймаг, нийслэл, сум, дүүргийн онцгой комиссын бүрэлдэхүүнийг тухайн шатны Засаг дарга батална.

4. Комиссыг онцгой байдлын асуудал эрхэлсэн Монгол Улсын сайд тэргүүлнэ. Комиссын даргын эзгүйд мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн Монгол Улсын сайд орлоно.

5. Комиссын хурал нийт гишүүдийн 60-аас доошгүй хувийн ирцэтэй бол хүчин төгөлдөр болох бөгөөд хэлэлцсэн асуудлыг хуралд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэж, тэмдэглэл гаргана.

6. Комиссын дарга нь холбогдох хууль тогтоомж, энэ журмаар олгогдсон үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлаар албан даалгавар гаргаж болно.

7. Комиссоос гаргасан шийдвэрийг төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэд өмчийн төрөл, хэлбэр үл харгалзан дагаж мөрдөнө.

8. Комиссын өдөр тутмын үйл ажиллагааг Улсын онцгой комисст онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн онцгой комисст тухайн шатны Засаг даргын Тамгын газар дахь онцгой байдлын асуудал эрхэлсэн нэгж, ажилтан эрхэлнэ.

## Хоёр. Комиссын үүрэг, эрх

9. Комисс дараахь үүрэгтэй байна:

9.1. гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшуулшгүй сэргээн босгох арга хэмжээний бэлтгэлийг хангуулах ажлыг төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллагаар гүйцэтгүүлэх, Засгийн газрын тогтоол шийдвэр, Монгол Улсын Ерөнхий сайдаас энэ чиглэлээр тусгайлан өгсөн үүргийг хэрэгжүүлэх;

9.2. гамшгийн голомтод аврах, хор уршгийг арилгах, хойшуулшгүй сэргээн босгох арга хэмжээг удирдан зохион байгуулах, эдгээр арга хэмжээнд оролцож байгаа байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;

9.3. гамшигтай тэмцэх асуудлаар гадаад орон, олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах, арга туршлагаа харилцан солилцох;

9.4. гамшгийн цагийн байдалд өгсөн үнэлэлтийг хэлэлцэх;

9.5. гамшиг бүхий нутаг дэвсгэр, бүс нутгийн холбогдох байгууллага, аж ахуйн нэгжийг

бэлэн байдлын зэрэгт илжжүүлэх, хорио цээрийн дэглэм тогтоох талаар санал боловсруулж Засгийн газарт оруулан шийдвэрлүүлэх, хэрэгжүүлэх, мөрдүүлэх ажлыг зохион байгуулах;

9.6. гамшгийн цагийн байдлын үнэлгээг мэргэжлийн байгууллага, шинжээчдээр хийлгэх;

9.7. гамшгийн голомтод ажиллагсдын ажиллах журмыг тухайн нөхцөл, цагийн байдалтай уялдуулан тогтоон өгч, хэрэгжилтийн явцад хяналт тавих;

9.8. гамшгийн голомтод Засгийн газраас олгосон бараа, материал болон олон улс, хүмүүнлэгийн тусламж хүргэх болон тээвэрлэх явцад хяналт тавих;

9.9. гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшуулшгүй сэргээн босгох, нэрвэгдэгсдэд шуурхай тусламж үзүүлэх, нүүлгэн илжжүүлэх ажилд шаардагдах хүн хүч, техник хэрэгслийг зохих журмын дагуу дайчлан гаргах асуудлыг төрийн захиргааны болон бусад байгууллага, албан тушаалтантай хамтран шийдвэрлэж зохицуулах, шаардлагатай нэмэгдэл хүн хүч, техник хэрэгсэл дайчлан гаргах санал боловсруулан зохих хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлэх;

9.10. Комиссоос олон нийтэд хүргэх анхааруулга, санамж болон авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнийхээ талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр шуурхай мэдээлж байх.

10. Комисс дараахь эрхтэй байна:

10.1. гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшуулшгүй сэргээн босгох арга хэмжээг хэрэгжүүлэх асуудлаар төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллагын удирдлагад үүрэг даалгавар өгч, биелэлтийг хангуулах, гүйцэтгэлд нь хяналт тавих;

10.2. гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшуулшгүй сэргээн босгох арга хэмжээнд холбогдох төрийн захиргааны болон мэргэжлийн байгууллага, албан тушаалтан, гадаадын хөрөнгө оруулалттай болон дотоодын аж ахуйн нэгж, иргэдийг хууль тогтоомжийн дагуу өмчийн төрөл, хэлбэр үл харгалзан татан оролцуулах;

10.3. холбогдох байгууллага, албан тушаалтнаас шаардлагатай тайлан, мэдээ, мэдээлэл, судалгаа гаргуулан авах, мэдээлэл, илтгэлийг хэлэлцэж, шийдвэр гарган биелүүлэхийг шаардах;

10.4. гамшгийн голомтод хэрэгжүүлж байгаа арга хэмжээг шалгаж дүгнэлт гаргах, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах арга хэмжээ авах;

10.5. гамшгийн аюулаас аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээнд шаардлагатай тохиолдолд зэвсэгт хүчин болон бусад хүчний байгууллагуудын анги, салбарын бие бүрэлдэхүүн, тусгай зориулалтын техник хэрэгслийг холбогдох хууль тогтоомжийн дагуу дайчлан ажиллуулах;

10.6. гамшигт нэрвэгдэгсдэд тусламж үзүүлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажилд шаардагдах нэмэлт зардал болон бараа материал, тоног төхөөрөмжийн тухай асуудлыг Засгийн газарт оруулж шийдвэрлүүлэх;

10.7. Комиссоос олон нийтэд хүргэх анхааруулга, санамж болон авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар мэдээлэл хийхдээ хэвлэл, мэдээллийн хэрэгслийг холбогдох журмын дагуу оролцуулах.

### Гурав. Орон нутгийн онцгой комисс

11. Улсын онцгой комиссоос баталсан үлгэрчилсэн журмыг үндэслэн аймаг, нийслэл, сум, дүүргийн онцгой комиссын ажиллах журмыг аймаг, нийслэлийн Засаг дарга батална.

12. Тухайн шатны онцгой комиссын дарга нь Засаг дарга, уг комиссын орлогч дарга нь аймаг, нийслэлийн онцгой байдлын газар, хэлтсийн дарга, сум, дүүрэгт холбогдох ажилтан байна.

13. Аймаг, нийслэлийн онцгой комисс нь нутаг дэвсгэртээ гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг зохион байгуулж хэрэгжүүлэх, Улсын онцгой комиссоос

өгсөн үүрэг, даалгаврын биелэлтийг хангах үүрэгтэй ажиллана.

14. Аймаг, нийслэл, сум, дүүргийн онцгой комисс нь энэ дүрмийн 9.1, 9.2, 9.4, 9.8, 9.9, 9.10-т заасан үүргийг биелүүлэн, 10.2, 10.3, 10.4, 10.7-д заасан эрхийг эдэлнэ.

15. Аймаг, нийслэлийн онцгой комисс нь гамшгийн үед зохион байгуулсан арга хэмжээ, үр дүнг гамшгийн нөхцөл байдал дууссан тухай бүр, авч хэрэгжүүлсэн арга хэмжээнийхээ тайланг жил бүрийн 2 дугаар сард багтаан Улсын онцгой комисст танилцуулна.

### Дөрөв. Комиссын зардал

16. Комиссын тухайн үеийн үйл ажиллагааны зардлыг онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын гаргасан тооцоо, Сангийн яамны саналыг үндэслэн Засгийн газраас санхүүжүүлнэ.

17. Аймаг, нийслэл, сум, дүүргийн онцгой комисс нь нутаг дэвсгэртээ гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдсон хөрөнгө, зардлыг тухайн жилийн төсөвтөө тусган, зориулалтын дагуу зарцуулна.

### Тав. Бусад зүйл

18. Комисс нь ажлын тайлангаа жил бүрийн 1 дүгээр сард багтаан Засгийн газарт танилцуулна.

19. Өгсөн үүрэг, даалгаврыг биелүүлээгүй байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэнд захиргааны шийтгэл ногдуулах саналаа комисс эрх бүхий холбогдох байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлнэ.

## — МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ —

2005 оны 9 дүгээр сарын 7-ны өдөр

Дугаар 184

Улаанбаатар хот

### Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Засгийн газрын 1997 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан буюу хүндэт тэмдгийн төрөл болон тэдгээрийг олгох эрх бүхий албан тушаалтны жагсаалт"-ын 12 дахь заалтын "Дэд бүтцийн хөгжлийн сайд" гэснийг "Зам, тээвэр, аялал жуулчлалын сайд" гэж, 32 дахь заалтын "Төрийн захиргааны албаны зөвлөлийн дарга" гэснийг "Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга" болгон тус тус өөрчилсүгэй.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Засгийн газрын 1997 оны 1 дүгээр сарын 2-ны

өдрийн 9 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Төмөр замын ажилтны сахилгын тусгай дүрэм"-ийн 8 дугаар зүйлийн "и" заалтыг хүчингүй болсонд тооцож, мөн дүрмийн 9 дүгээр зүйлд "и" гэснийг хассуулав.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Ц.ЭЛБЭГДОРЖ**

**МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**

**С.БАЯРЦОГТ**

**ЗАМ, ТЭЭВЭР, АЯЛАЛ  
ЖУУЛЧЛАЛЫН САЙД**

**Г.БАТХҮҮ**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2005 оны 9 дүгээр сарын 7-ны өдөр

Дугаар 185

Улаанбаатар хот

### Техникийн төвийг татан буулгах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалтыг үндэслэн 2005 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр батлагдсан Төрийн өмчөөс олон нийтийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Радио, телевизийн хэрэг эрхлэх газрын харьяа Дамжуулах байгууламжийн радио, телевизийн техникийн төвийг татан буулгаж чиг үүрэг, орон тоо, төсвийг нь Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газрын харьяа Мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн төвд шилжүүлсүгэй.

2. Дамжуулах байгууламжийн радио, телевизийн техникийн төвийг татан буулгасантай холбогдуулан тус төвийн эзэмшил дэх үндсэн болон эргэлтийн хөрөнгийг балансаас балансад орон тоо, төсвийн хамт Мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн төвд шилжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Н.Алтанхуяг, Мэдээлэл,

харилцаа холбоо, технологийн газрын дарга Ч.Сайханбилэг, Төрийн өмчийн хороо (З.ЭНХБОЛД)-нд даалгасугай.

3. Мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн төвийн дүрэм, зохион байгуулалтын бүтцийг зохих журмын дагуу шинэчлэн баталж мөрдүүлэх арга хэмжээ авахыг Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газрын дарга Ч.Сайханбилэгт үүрэг болгосугай.

4. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан "Радио, телевизийн хэрэг эрхлэх газрын бүтэц, удирдлагын орон тоог шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 1995 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 206 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн "в/Техникийн төв" гэснийг хүчингүй болсонд тооцугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

Ц.ЭЛБЭГДОРЖ

САНГИЙН САЙД

Н.АЛТАНХУЯГ

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2005 оны 9 дүгээр сарын 14-ний өдөр

Дугаар 187

Улаанбаатар хот

### Ажилд томилох тухай

Засгийн газрын тухай хуулийн 18<sup>3</sup> дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн албаны зөвлөлийн санал, дүгнэлтийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Даваадоржийн Ганболдыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Төмөр

замын хэрэг эрхлэх газрын даргаар томилсугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

Ц.ЭЛБЭГДОРЖ

ЗАМ, ТЭЭВЭР, АЯЛАЛ  
ЖУУЛЧЛАЛЫН САЙД

Г.БАТХҮҮ

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2005 оны 9 дүгээр сарын 14-ний өдөр

Дугаар 188

Улаанбаатар хот

### Нэрэмжит болгох тухай

Засгийн газрын 1998 оны 234 дүгээр тогтоолоор батлагдсан Түүхэн үйл явдлыг тэмдэглэх, төр, нийгмийн зүтгэлтэн, гавьяат үйлстнийг алдаршуулах, дурсгалыг нь хүндэтгэх ажлыг зохион байгуулах журмын 5 дугаар зүйлийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Хэнтий аймгийн Биндэр сумын 10 жилийн дунд сургуулийг Монгол Улсын Ардын

уран зохиолч Сэнгийн Эрдэнийн нэрэмжит болгосугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

Ц.ЭЛБЭГДОРЖ

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ  
УХААНЫ САЙД

П.ЦАГААН

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2005 оны 9 дүгээр сарын 14-ний өдөр

Дугаар 189

Улаанбаатар хот

### Үндэсний шигшээ баг байгуулах тухай

Биеийн тамир, спортын тухай хуулийн 7.1.3, 18.2, 20.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Олимпын наадмын тоглолтод ордог спортын төрлөөр олимпын наадам, дэлхий, тивийн аварга болон олон улсын шинжтэй тэмцээнд Монгол Улсыг төлөөлөн оролцох насанд хүрэгчдийн үндэсний шигшээ багийг Биеийн тамир, спортын улсын хорооны харьяанд 2005 оны IY улирлаас эхлэн байгуулан ажиллуулсугай.

2. Үндэсний шигшээ багийн үйл ажиллагаанд шаардагдах зардлыг жил бүрийн улсын төсөвт тусган санхүүжүүлж байхыг Сангийн

сайд Н.Алтанхуяг, Эрүүл мэндийн сайд Т.Ганди нарт үүрэг болгосугай.

3. Үндэсний шигшээ багийн залгамж халааг бэлтгэх зорилгоор залуучуудын, оюутны болон өсвөр үеийн шигшээ баг байгуулан ажиллуулах асуудлыг 2005 онд багтаан холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэхийг Эрүүл мэндийн сайд Т.Ганди, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

Ц.ЭЛБЭГДОРЖ

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД

Т.ГАНДИ

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2005 оны 9 дүгээр сарын 14-ний өдөр

Дугаар 191

Улаанбаатар хот

### Хамгаалалтын бүс тогтоох тухай

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 17.6, 17.8-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Нийслэлийн Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт байрлах Алтан-Өлгий дэх оршуулгын газрын хамгаалалтын бүсийг "А" хэсгийн урд зүгт 70 метр, баруун зүгт 30 метр, зүүн зүгт 80 метрийн хэмжээтэй байхаар, "Б", "В" хэсгийн баруун зүгт 50-80 метр, зүүн зүгт 50 метр, хойд зүгт 80 метрийн хэмжээтэй байхаар, "Г" хэсгийн баруун зүгт 10 метр, зүүн зүгт 90 метрийн хэмжээтэй байхаар тус тус тогтоосугай.

2. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийн хадгалалт, хамгаалалт, бүрэн бүтэн байдлыг хангаж, хамгаалалтын бүсэд барилга байгууламж барих, айл өрх буулгахыг хориглох арга хэмжээ авахыг нийслэлийн Засаг дарга М.Энхболд, Дотоодын цэргийн дарга, хошууч генерал Д.Сандаг-Очир нарт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

С.БАЯРЦОГТ

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2005 оны 9 дүгээр сарын 14-ний өдөр

Дугаар 194

Улаанбаатар хот

### Хэлэлцээр батлах тухай

Олон улсын гэрээний тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

2005 оны 7 дугаар сарын 19-ний өдөр Улаанбаатар хотноо гарын үсэг зурсан "Анкара дахь Монгол Улсын Элчин сайдын яам, Улаанбаатар дахь Бүгд Найрамдах Турк Улсын Элчин сайдын яаманд гүрд харилцан түрээсээр ашиглуулах

тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Турк Улсын Засгийн газар хоорондын Хэлэлцээр"-ийг баталсугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН  
ШАДАР САЙД

Ч.УЛААН

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.  
"Төрийн Мэдээлэл" эмтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12,

Төрийн ордон

☎ 265958

Индекс 14003

Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын  
Хэлэлцэх хэсэгт хэллэв.

☎ 267497

Хэвлэлийн хуудас 1.5